

  
МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/247

Улаанбаатар хот

Г  
Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн,  
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусlamж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын 10.1 дэх хэсэг, МОН/006 төслийн баримт бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Зүрх судасны үндэсний төв ба Зүрх судасны тусlamж үйлчилгээг уялдуулан сайжруулах нь" МОН/006 Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. МОН/006 Төслийн удирдах хорооны үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын тусlamж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам" болон холбогдох бусад хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төслийн удирдах хорооны дарга, Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/210 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080797

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 06 сарын 20-ны өдрийн  
4. дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**“МОНГОЛ УЛСЫН ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БА ЗҮРХ СУДАСНЫ  
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ УЯЛДУУЛАН САЙЖРУУЛАХ НЬ” МОН/006  
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Дэд дарга: Люксембургийн Их Гүнт Улсын Гадаад хэргийн яамны төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Зүрх судасны үндэсний төвийн дарга
- Гишүүд : Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга;
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга;
- Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга;
- Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга /зөвшилцсөнөөр/;
- Люксембургийн Хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн төлөөлөл

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 06 сарын 20-ны өдрийн  
А/ дугаар тушаалын 2 дугаар хавсралт  
*Б.Ч.*

**“МОНГОЛ УЛСЫН ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БА ЗҮРХ СУДАСНЫ  
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ УЯЛДУУЛАХ САЙЖРУУЛАХ НЬ” МОН/006  
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ, АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг:Зорилго

- 1.1 Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг стратегийн удирдлагаар хангах;
- 1.2 Төслийн үйл ажиллагаа Үндэсний бодлого, стратегитай нийцэж буй эсэхэд хяналт тавих.

Хоёр: Удирдах хорооны чиг үүрэг

- 2.1 Төслийн баримт бичигт шаардлагатай нэмэлт өөрчлөлт орох тохиолдолд хянан батлах;
- 2.2 Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан, батлах;
- 2.3 Жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн баталгаажуулах;
- 2.4 Үндэсний болон олон улсын стратеги, хөтөлбөр төслүүдтэй хамтын ажиллагааг зохицуулан, нийцүүлэх;
- 2.5 Бусад яаралтай тулгамдсан асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэж, шийдвэр гаргах.

Гурав. Үйл ажиллагаа

- 3.1 Төсөл хэрэгжих хугацаанд ТУХ нь жил тутам нэгээс дээш удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулж, явцын үнэлгээний дагуу хэрэгжилтийг түргэтгэх арга хэмжээ болон тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх болно.
- 3.2 Зүрх судасны үндэсний төвийн дарга нь ТУХ-ны Нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж, хурлын тов, хэлэлцэх асуудлыг боловсруулан ТУХ-ны даргаар батлуулж, хурлын урилгыг хэлэлцэх асуудлын хамт ТУХ-ны гишүүдэд ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, хурлын тэмдэглэл хөтөлнө.
- 3.3 ТУХ-ны дарга нь Эрүүл мэндийн сайд, бусад холбогдох талуудад төслийн явцыг тайлagnана. Төслийн зохицуулагч танилцуулгыг бэлтгэж өгнө.
- 3.4 ТУХ-ны гишүүдийн 70-аас дээш хувь биечлэн оролцсон тохиолдолд хурлын ирцийг бүрдсэнд тооцож хурлыг нээнэ.
- 3.5 Шаардлагатай тохиолдолд бусад олон улсын байгууллага, хандивлагчид болон техник туслалцааны агентлагуудын төлөөллийг ажиглагчаар урьж оролцуулж болно.
- 3.6 Хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Гишүүд санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.